

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР ИЛТГЭХ ХУУДАС

УИХ-ЫН ГИШҮҮН АСАН М.ЧИМЭДЦЭРЭНГИЙН НЭРЭМЖИТ "ЧИНГИС МАСТЕР КРОСС 2023" 23 ДАХЬ УДААГИЙН УРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ

2023.03.20


Дархан-Уул аймаг


УИХ-ын гишүүн асан М.Чимэдцэрэнгийн нэрэмжит "Чингис мастер кросс 2023" 23 дахь удаагийн уралдааныг 2023 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Дархан-Уул аймагт зохион байгууллаа. Нээлт Найрамдал талбайд 09:30 минутад эхэлж уралдаан антентай ууланд 11:00 цагаас 17:00 цаг хүртэл үргэлжиллээ. Тус уралдаанд Монголын мастер кросс ангиллын нийт 63 тамирчин оролцож, тэмцээн 7 гараатай, хэсгийн 4, хагас шигшээ 2, финалын нэг гараанаас шилдгүүд тодорлоо. Уралдаан зохион байгуулах ажлын хэсгийн хурал 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр аймгийн Тамгын газрын дарга О.Хүрэлчулуун даргын өрөөнд хуралдаж аймгийн Соёл, урлагийн газар, Захирагчийн ажлын алба, Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн ОНӨААТҮГ, Дархан хот тохижилт байгууллагууд оролцлоо.

Уралдааны өдөр Соёл, урлагийн газар Худалдаа үйлчилгээ чөлөөтэй, шууд дамжуулалтын тухай постер бэлтгэж уралдаанд хөдлөх замын маршрутыг "Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар" пэйж хуудсанд байршуулж аймгийн ЗДТГ-ын Мэдээлэл технологийн албанд постерийг өглөө.



Мөн уралдааны үеэр худалдаа, үйлчилгээ эрхлэгчид нээлттэй, нийтийн бие засах газар үнэ төлбөргүй үйлчилгээ, хог цэвэрлэгээ, эрүүл ахуйн хяналт шалгалт тогтмол хийгдэж эрүүл мэндийн түргэн тусламж, онцгой байдал, цагдаагийн байгууллага зэрэг шуурхай ажлын хэсэг ажиллаж байгаа тухай тогтмол мэдээлж ажиллалаа. Дээрх хуралд оролцсон байгууллагуудтай хамтран ажиллаж тогтмол хяналт хийж мэдээлэл хүргэж ажиллалаа.





Хүнс, хөдөө аж ахуйн газар:

Тус уралдааны үеэр ХХААГ-ын хяналтын албанаас ажлын хэсэг ажиллаж хуушуур 23, шорлог 3, хүнсний худалдааны 2 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 1 аж ахуйн нэгж, 27 иргэний худалдаа үйлчилгээний цэгүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн 19% нь Улаанбаатар, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн Хонгор сумаас ирсэн иргэд ажиллалаа.



Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн ОНӨААТҮГ:

Найрамдал талбайн нээлтэд 8 ширхэг хогийн савыг байршуулж уралдааны талбайд 6 ширхэг био нойл, 9ш хогийн сав байрлуулж 2 цаг тутамд цэвэрлэгээ, ариутгал хийж нойлын цаас, хогны савыг цэвэрлэж иргэдэд тав тухтай үнэгүй үйлчилгээ үзүүлсэн. Тэмцээний дараа 19:30 цагт орчны хогийг бүрэн цэвэрлэж био нойл хогны саваа хурааж ажиллалаа.



Дархан хот тохижилт үйлчилгээний газар:

Дархан хот тохижилт үйлчилгээний газрын зам талбайн 2, 4 дүгээр хэсгийн нийт 30 зам талбайн үйлчлэгч нар уралдааны зам болон ойролцоох эзэнгүй зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийлээ. Дархан-Уул аймгийн 6 дугаар багийн “Гэгээ” хүнсний дэлгүүрээс Дархан хаалга хүртэлх зам болон Авто уралдаан зохион байгуулагдах газрын эзэнгүй талбайн хуурай хог хаягдлыг цэвэрлэж хог тээврийн 1 машин ажиллаж 3 рейс хогийг хогийн цэгт татан зайлуулсан.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР